

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт
ААН	Аж ахуйн нэгж
ХК	Хувьцаат компани
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ХХААХҮЯ	Хүнс хөдөө аж ахуйн хөнгөн үйлдвэрийн яам
САГ	Санхүүгийн аудитын газар
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТХН	Төсөл хэрэгжүүлэгч нэгж

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
3.Аудитын тайлан.....	10
3.1. Ерөнхий зүйл.....	10
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй	10
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт	11
3.4. Материаллаг байдал	11
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	11
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	12
3.7. Шилэн дансны мэдээлэл	13
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	13
3.9. Аудитын илрүүлэлт.....	13
Залруулсан алдаа	13
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	13
Аудитын зөвлөмж.....	14
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	14
4. Менежментийн захидал	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	16



ЭКСПОРТЫГ ДЭМЖИХ ТӨСЛИЙН
ЗОХИЦУУЛАГЧ А.ХАШЦЭЦЭГ ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2021.02.25 № 07/525
танай _____ -ны № _____ -т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй санал дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Экспортыг дэмжих төслийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Экспортыг дэмжих төслийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга илэрхийлсэн толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторов ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Төсөл хэрэгжүүлэгч нэгжийн удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Төсөл хэрэгжүүлэгч нэгж нь жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 дэд зорилтын хүрээнд 58 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 47 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан
/төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,484,446,127.22</u>	<u>3,051,916,740.82</u>
МӨНГӨН ХӨРӨНГӨ	1,484,446,127.22	3,050,312,090.82
Кассанд байгаа бэлэн мөнгө	-	-
Банканд байгаа бэлэн мөнгө	1,484,446,127.22	3,050,312,090.82
Төгрөг	-	320,407,167.10
Төрийн сангийн харилцах	-	320,407,167.10
Гадаад валют	1,484,446,127.22	2,729,904,923.72
Арилжааны банк дахь харилцах	1,484,446,127.22	2,729,904,923.72
БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	-	-
АВЛАГА	-	1,604,650.00
Бусад авлага	-	1,604,650.00
Хувь хүмүүсээс авах авлага	-	1,604,650.00
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>21,712,092.45</u>	<u>79,867,407.58</u>
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	21,712,092.45	79,867,407.58
Биет хөрөнгө	16,106,492.45	75,026,207.58
Машин тоног төхөөрөмж (компьютер)	40,748,500.00	69,668,322.00
Хуримтлагдсан элэгдэл	(34,794,791.67)	(42,285,003.06)
Тавилга, аж ахуйн эд хогшил	13,840,162.00	50,033,705.36
Хуримтлагдсан элэгдэл	(3,687,377.88)	(6,351,366.72)
Бусад үндсэн хөрөнгө	-	4,169,000.00
Хуримтлагдсан элэгдэл	-	(208,450.00)
Биет бус хөрөнгө	5,605,600.00	4,841,200.00
Программ хангамж	7,644,000.00	7,644,000.00
Хуримтлагдсан элэгдэл	(2,038,400.00)	(2,802,800.00)
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,506,158,219.67</u>	<u>3,131,784,148.40</u>
НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	<u>92,899.70</u>
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	92,899.70
Өглөг	-	92,899.70
Бусад өглөг	-	92,899.70
Татварын өглөг /ТӨҮГ/	-	92,899.70
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,506,158,219.67</u>	<u>3,131,691,248.70</u>
Засгийн газрын хувь оролцоо	1,506,158,219.67	3,131,691,248.70
Хуримтлагдсан үр дүн	1,506,158,219.67	3,131,691,248.70
Өмнөх үеийн үр дүн	2,380,292,025.00	1,506,158,219.67
Тайлант үеийн үр дүн	(874,133,805.33)	1,625,533,029.03
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,506,158,219.67</u>	<u>3,131,784,148.40</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан
/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	888,203,102.62	6,472,405,651.72
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	888,203,102.62	6,472,405,651.72
Нийтлэг татварын бус орлого	888,203,102.62	6,472,405,651.72
Төсөв байгууллагын өөрийн орлого	888,203,102.62	6,472,405,651.72
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	20,536,181.13	5,336,801.82
Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	867,666,921.49	6,467,068,849.90
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	1,804,281,308.99	4,893,699,593.68
УРСГАЛ ЗАРДАЛ	1,804,281,308.99	4,893,699,593.68
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,804,281,308.99	4,893,699,593.68
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	203,984,116.30
Үндсэн цалин	-	203,984,116.30
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	25,497,926.99
Тэтгэврийн даатгал	-	25,497,926.99
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	15,167,250.00	104,485,320.00
Байрны түрээс	15,167,250.00	104,485,320.00
Хангамж, бараа материалын зардал	3,037,766.50	11,664,309.31
Бичиг хэрэг	625,454.54	5,582,895.36
Шуудан, холбоо, интернетийн төлбөр	2,412,311.96	6,081,413.95
Томилолт, зочны зардал	-	142,000.00
Дотоод албан томилолт	-	142,000.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,767,675,266.23	4,536,798,870.85
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,767,675,266.23	4,536,798,870.85
Бараа үйлчилгээний бусад зардал	18,401,026.26	11,127,050.23
Бараа үйлчилгээний бусад зардал	2,669,776.72	-
Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	15,731,249.54	11,127,050.23
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	(916,078,206.37)	1,578,706,058.04
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН (IV)	41,944,401.04	46,826,970.99
Гадаад валютын ханшийн зөрүүний олз	41,944,401.04	46,826,970.99
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)	-	-
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	(874,133,805.33)	1,625,533,029.03

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	888,203,102.62	6,472,405,651.72
ТАТВАРЫН ОРЛОГО	-	-
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	888,203,102.62	6,472,405,651.72
Нийтлэг татварын бус орлого	888,203,102.62	6,472,405,651.72
Төсөв байгууллагын өөрийн орлого	888,203,102.62	6,472,405,651.72
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	20,536,181.13	5,336,801.82
Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	867,666,921.49	6,467,068,849.90
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,788,550,059.45	4,884,084,293.75
УРСГАЛ ЗАРДАЛ	1,788,550,059.45	4,884,084,293.75
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,788,550,059.45	4,884,084,293.75
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	203,984,116.30
Үндсэн цалин	-	203,984,116.30
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	25,497,926.99
Тэтгэврийн даатгал	-	25,497,926.99
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	15,167,250.00	104,485,320.00
Байрны түрээс	15,167,250.00	104,485,320.00
Хангамж, бараа материалын зардал	3,037,766.50	11,664,309.31
Бичиг хэрэг	625,454.54	5,582,895.36
Шуудан, холбоо, интернетийн төлбөр	2,412,311.96	6,081,413.95
Томилолт, зочны зардал	-	142,000.00
Дотоод албан томилолт	-	142,000.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,767,675,266.23	4,538,310,621.15
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,767,675,266.23	4,538,310,621.15
Бараа үйлчилгээний бусад зардал	2,669,776.72	-
Бараа үйлчилгээний бусад зардал	2,669,776.72	-
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	(900,346,956.83)	1,588,321,357.97
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	-	-
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	-	69,282,365.36
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	69,282,365.36
Дотоод эх үүсвэрээр	-	69,282,365.36
Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	69,282,365.36
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-	(69,282,365.36)
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН (VII)	41,944,401.04	46,826,970.99
Бусад эх үүсвэр	41,944,401.04	46,826,970.99
Гадаад валютын ханшийн зөрүүний олз	41,944,401.04	46,826,970.99
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	(858,402,555.79)	1,565,865,963.60
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,342,848,683.01	1,484,446,127.22
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,484,446,127.22	3,050,312,090.82

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

				/төгрөгөөр/
Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	2,380,292,025.00	2,380,292,025.00
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	2,380,292,025.00	2,380,292,025.00
Тайлант үеийн үр дүн	-	-	(874,133,805.33)	(874,133,805.33)
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	1,506,158,219.67	1,506,158,219.67
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	1,506,158,219.67	1,506,158,219.67
Тайлант үеийн үр дүн	-	-	1,625,533,029.03	1,625,533,029.03
2020 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	-	-	3,131,691,248.70	3,131,691,248.70

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,917,059,300.00	4,953,366,659.11	963,692,640.89	83.7
УРСГАЛ ЗАРДАЛ	5,851,945,900.00	4,888,253,293.75	963,692,606.25	83.5
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,851,945,900.00	4,888,253,293.75	963,692,606.25	83.5
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	206,434,100.00	203,984,116.30	2,449,983.70	98.8
Үндсэн цалин	206,434,100.00	203,984,116.30	2,449,983.70	98.8
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	25,497,900.00	25,497,926.99	(26.99)	100
Тэтгэврийн даатгал	25,497,900.00	25,497,926.99	(26.99)	100
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	104,485,300.00	104,485,320.00	(20.00)	100
Байрны түрээс	104,485,300.00	104,485,320.00	(20.00)	100
Хангамж, бараа материалын зардал	12,510,200.00	11,664,309.31	845,890.69	93.2
Бичиг хэрэг	5,810,300.00	5,582,895.36	227,404.64	96.1
Шуудан, холбоо, интернетийн төлбөр	6,699,900.00	6,081,413.95	618,486.05	90.8
Томилолт, зочны зардал	142,000.00	142,000.00	-	100
Дотоод албан томилолт	142,000.00	142,000.00	-	100
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,502,876,400.00	4,542,479,621.15	960,396,778.85	82.5
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,502,876,400.00	4,542,479,621.15	960,396,778.85	82.5
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	65,113,400.00	65,113,365.36	34.64	100
Бусад хөрөнгө	65,113,400.00	65,113,365.36	34.64	100
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	5,917,059,300.00	6,472,405,651.72	(555,346,351.72)	109
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	5,917,059,300.00	6,472,405,651.72	(555,346,351.72)	109
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	5,336,801.82	(5,336,801.82)	-
Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	5,917,059,300.00	6,467,068,849.90	(550,009,549.90)	109
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	1,484,446,127.22	-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	3,050,312,090.82	-	-
АЖИЛЛАГСДЫН ТОО	6	6	-	-

3.Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Экспортыг дэмжих төслийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг төслийн зохицуулагч А.Хашцэцэг танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд ажилтнуудын цалинг журам, зааврын дагуу үнэн, зөв тооцох, үйл ажиллагааны төлөвлөгөөний гүйцэтгэлийн биелэлтийг хангах, зээлийн хөрөнгийг үр ашигтай зарцуулах талаар өгсөн зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 19-нөөс 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Үндэсний аудитын газрын захиалгаар “Грант Торнтон аудит” ХХК-ийн Ерөнхий захирал, гэрээт ажлын партнер Б.Осоргарав, Партнер, чанарын хянагч Н.Эрдэнэцог нар удирдаж, аудитын менежер Б.Дэлгэрмаа, аудитор М.Батцоож нар хариуцаж хэрэгжүүлэв.

Экспортыг дэмжих төслийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2021 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 21/07 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Экспортыг дэмжих төсөл нь уул уурхайн бус салбарын жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн экспортын чадавхыг бэхжүүлэх болон экспортын зах зээлд нэвтрэх боломжийг өргөжүүлэх зорилготой. Төсөл нь гадаадын зээл болон буцалтгүй тусламжийн эх үүсвэрээр санхүүждэг.

Төсөл хэрэгжүүлэгч нь үндсэн зорилгоо хэрэгжүүлэх дэд зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг явуулдаг байна. Үүнд:

- Бүрэлдэхүүн 1: Экспортын шинэ төрлийн санхүүгийн бүтээгдэхүүнийг хөгжүүлэх,
- Бүрэлдэхүүн 2: Экспортын өрсөлдөх чадвар, зах зээлд нэвтрэх боломжийг нэмэгдүүлэх,
- Бүрэлдэхүүн 3: Баталгаажуулалтын үйлчилгээ, чанарын удирдлагыг сайжруулах,
- Бүрэлдэхүүн 4: Төслийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх.

Төслийн дөрвөн дэд зорилтын хүрээнд нийт 58 үйл ажиллагааг төлөвлөснөөс 2 ажлыг Ковид-19 цар тахлын хорио, цээрийн дэглэмээс шалтгаалан хэрэгжүүлээгүй, 28 ажлыг бүрэн хийж дуусгасан, 28 ажлыг төлөвлөсөн хугацааны дагуу хэрэгжүүлсээр байна. Тайлант хугацаанд хэрэгжүүлсэн ажлуудыг хураангуйлвал:

- Бүрэлдэхүүн 1: Үндэсний давхар даатгал ХК-ийн экспортын даатгалын газар, бусад холбогдох талуудын чадавхыг бэхжүүлэн сургалт, судалгааны ажлыг хийж гүйцэтгэсэн,
- Бүрэлдэхүүн 2: Экспортлогч болон экспортлох зорилготой жижиг, дунд ААН-үүд, иргэдийг сургалтад хамруулж, тусгайлсан захиалгат сургалтуудыг хийж, экспортыг дэмжих, тулгамдаж буй нийтлэг асуудлуудыг шийдвэрлэх хүрээнд уулзалт, хэлэлцүүлэг, семинаруудыг зохион байгуулсан,
- Бүрэлдэхүүн 3: Олон улсын зөвлөх үйлчилгээний байгууллагыг худалдан авах ажиллагааны эх үүсвэрийн аргаар сонгон шалгаруулж хамтран ажиллахаар болсон,

- Бүрэлдэхүүн 4: Төслийн удирдлага, худалдан авалт, санхүүгийн удирдлага, хяналт шинжилгээ-үнэлгээний ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд томоохон өөрчлөлт ороогүй байна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Экспортыг дэмжих төслийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллага нь Дэлхийн банкнаас гаргасан “Санхүүгийн гарын авлага” болон Сангийн сайдын 2007 оны 11 сарын 30-ны өдрийн 326 дугаар тушаалаар батлагдсан “Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ыг нягтлан бодох бүртгэлд мөрдөж байна.

2020 онд ХХААХҮЯ-наас санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны 6 дугаар сарын 30-ны санхүүгийн үр дүнгийн тайлангийн 143,794.6 мянган төгрөгийн нийт зардлаас 1 хувиар буюу 1,437.9 мянган төгрөгөөр тооцсон, ба гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын хувь хэмжээг өөрчлөөгүй.

Гүйцэтгэлийн үе шатанд 2020 оны 12 дугаар сарын 31-ний санхүүгийн үр дүнгийн тайлангийн 4,893,699.5 мянган төгрөгийн нийт зардлаас 1 хувиар тооцон 48,936.9 мянган төгрөгөөр тогтоолоо.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Экспортыг дэмжих төслийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,625,625.9 мянган төгрөгөөр буюу 107.9 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

			/мянган төгрөг/
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	1,484,446.1	3,050,312.1	1,565,866.0
Авлага	-	1,604.6	1,604.6
Үндсэн хөрөнгө	21,712.1	79,867.4	58,155.3
Нийт хөрөнгө	1,506,158.2	3,131,784.1	1,625,625.9
Өр төлбөр	-	92.9	92.9
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,506,158.2	3,131,691.2	1,625,533.0
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,506,158.2	3,131,784.1	1,625,625.9

Өмнөх оны үзүүлэлтээс дараах дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна.

Тухайлбал:

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 3,050,312.1 мянган төгрөг болж 1,565,866.0 мянган төгрөгөөр өссөн нь цар тахалтай холбоотойгоор хэрэгжүүлэх байсан сургалт, судалгааны ажлууд хойшилсноос шалтгаалжээ.

Авлага дансны үлдэгдэл 1,604.6 мянган төгрөг болж өссөн нь харилцагч байгууллагатай 2020 оны 12 сарын 30-нд гэрээ дүгнэж, тооцоо нийлээд үлдэгдэл төлбөрийг харилцагч байгууллагаас шилжүүлсэн бөгөөд төрийн сангийн гүйлгээ хийх тасалбар болголтоос үүдэн төлбөр нь төсөл хэрэгжүүлэгч нэгжийн төрийн сангийн дансанд 2021 оны 1 дүгээр сарын 5-ны өдөр буцаан төлөгдсөн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 79,867.4 мянган төгрөг болж 58,155.3 мянган төгрөгөөр өссөн нь төсөл хэрэгжүүлэгч нэгжийн дотоод зохион байгуулалт, боловсон хүчний бүтэц өөрчлөгдсөнтэй холбоотойгоор компьютер, түүний дагалдах хэрэгслүүдийг шинээр худалдан авснаас шалтгаалжээ. Үндсэн хөрөнгийн данс нь урсгал төсвийн худалдан авалтаар 69,282.3 мянган төгрөгийн компьютер, түүний дагалдах хэрэгслүүдээр нэмэгдсэн байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 92.9 мянган төгрөг болж өссөн нь төсөл хэрэгжүүлэгч нь хувь хүнээс худалдан авсан бараа, ажил үйлчилгээнд ХХОАТ суутган төлдөг бөгөөд жилийн эцэст хувь хүнээс худалдан авсан худалдан авалтуудын ХХОАТ-ын тооцооллын зөрүүгээс шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 3,131,691.2 мянган төгрөг болж 1,625,533.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь цар тахалтай холбоотойгоор хэрэгжүүлэх байсан сургалт, судалгааны ажлууд хойшилсон учир тайлант хугацааны санхүүжилтийн орлого нь зарцуулалтаас их гарч хуримтлагдсан үр дүнг нэмэгдүүлснээс шалтгаалжээ.

Экспортыг дэмжих төслийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 5,584,202.5 мянган төгрөгөөр буюу 628 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан данс нь гадаад зээлээр санхүүжих орлого байна. Энэ нь төсөл хэрэгжүүлэгч нэгжийн шинэчлэсэн зорилтын хүрээнд үйл ажиллагааны чиглэлээ өргөжүүлэн, өмнөх онтой харьцуулахад илүү санхүүжилт хүлээн авснаас шалтгаалсан байна.

Нийт зардлын хувьд өмнөх оноос 3,089,418.2 мянган төгрөгөөр буюу 171 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлттэй харьцуулахад бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлуудад материаллаг өөрчлөлт гарсан байна. Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал өссөн нь төсөл хэрэгжүүлэгч нэгжийн бүтэц, зохион байгуулалт өөрчлөгдөн шинээр сургалтын үйл ажиллагааг түлхүү зохион байгуулахаар төлөвлөн, их талбайтай оффисыг түрээсэлснээс шалтгаалсан байна. Мөн төсөл хэрэгжүүлэгч нэгжийн дотоод зохион байгуулалт, дэд зорилтууд өөрчлөгдсөнтэй холбоотойгоор “Аж ахуйн нэгжүүдэд цар тахлын хүндрэлийг даван туулахад санхүүгийн дэмжлэг үзүүлэх” гэсэн дэд зорилт нэмэгдэн, тус зорилтын хүрээнд төслөөс Ажилгүйдлийн даатгалын санд 4,267,500.0 мянган төгрөгийг төвлөрүүлсэн учир бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөрийн дүн өссөн байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 5,917,059.3 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 5,917,059.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэн батлуулсан байна.

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 4 дэд зорилтын хүрээнд авч хэрэгжүүлэх 58 арга хэмжээг санхүүжүүлэхээр 5,917,059.3 мянган төгрөгийн төсөв баталснаас 5,917,059.3 мянган төгрөгийг гадаадын зээлийн эх үүсвэрээр санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр гадаадын зээлийн эх үүсвэрээс 6,467,068.8 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 5,336.8 мянган төгрөг, нийт 6,472,405.6 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 4,953,366.6 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 4,953,366.6 мянган төгрөг буюу 83.7 хувьтай байгаа нь бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардлыг 960,396.7 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь сургалт зохион байгуулах арга хэмжээний гүйцэтгэл 21.0 хувьтай, холбогдох зарцуулалтыг хийгээгүйгээс шалтгаалсан байна.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор төсөл хэрэгжүүлэгч нэгж нь www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 19 төрлийн 149 мэдээллээс 61 мэдээллийг хугацаанд нь, 84 мэдээллийг хугацаа хоцроон оруулсан, 4 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлагын хэрэгжилт хангалтгүй, зөрчил давтагдан гарсан байна.

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 35,910.6 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 4,254.4 мянган төгрөгийн 2 алдааг залруулж, 30,585.4 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлж, 1,070.8 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Төсөл хэрэгжүүлэгч нэгж нь ам.долларын тусгай дансны үлдэгдэлд хаалтын ханшаар тэгшитгэл хийхдээ санамсаргүй алдаа гарган ам.долларын үлдэгдлийг бодит үлдэгдлээс зөрүүтэй дүнгээр тооцоолсноос мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 85.4 мянган төгрөгөөр илүү илэрхийлсэн байсныг залруулав.
2. Тайлант хугацаанд шинээр түрээсэлсэн оффисын байранд 4,169.0 мянган төгрөгийн металл вакум хаалга, хана хийсэн бөгөөд тус үндсэн хөрөнгийг тайлант хугацааны зардалд хүлээн зөвшөөрснийг үндсэн хөрөнгөд бүртгүүлж, залруулав.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 31,656.2 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 30,585.4 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлээ.

1. Төсөл хэрэгжүүлэгч нэгж нь шилэн дансны цахим хуудсанд байршуулах 19 төрлийн 149 мэдээллээс 4 мэдээллийг огт мэдээлээгүй, 84 мэдээллийг хугацаа хоцорч мэдээлсэн байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т "Мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3-т "Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" 6 дугаар зүйлийн 6.4.1 "Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлтийг долоо хоногийн дотор мэдээлнэ" гэсэн заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

2. Төсөл хэрэгжүүлэгч нэгж нь 2020 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон санхүүгийн тайланд 1,604.6 мянган төгрөгийн авлага, 92.8 мянган төгрөгийн өглөгийн үлдэгдэл тайлагнасан байна. Энэ нь "Төсвийн тухай хууль"-ийн 6 дугаар зүйлийн 6.4.8 "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн "эрх ба үүрэг", "толилуулга" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

3. Төсөл хэрэгжүүлэгч нэгж нь тайлант хугацаанд 1 м.км-ын үнэлгээ нь сарын 43.3 мянган төгрөг бүхий 268 м.кв оффисын талбайг нийт 104,485.3 мянган төгрөгөөр түрээсэлсэн байна. Энэхүү зардлыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2018 оны 1 дүгээр сарын 09-ний өдрийн 01 дугаар хуралдааны шийдвэр 1-р зүйлийн 1.1 "Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компаниудын бусдаас түрээсэлдэг байх талбайн 1 м.кв талбайн түрээсийн төлбөрийн дээд хязгаарыг 30,000.0 мянган төгрөгөөс ихгүй байлгах", Засгийн газрын 2002 оны 120 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Төрийн албан хаагчийн албан ажлын унаа, өрөөний талбайн хэмжээ, тавилга, хэрэгслийн нийтлэг жишиг"-ийн 4 дүгээр зүйл "Нэг дэс түшмэлд ногдох албан ажлын өрөөний талбай дунджаар 8 ам метр байна" гэсэн заалтуудыг үндэслэн давтан тооцоолоход төсөл хэрэгжүүлэгч нэгжийн оффисын ашигтай талбайн хэмжээ 210 м.кв, нийт түрээсийн зардал 75,600.0 мянган төгрөг байвал зохистой байна. Энэ нь "Төсвийн тухай хууль"-ийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэсэн заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн "толилуулга" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 1,070.8 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Төсөл хэрэгжүүлэгч нэгж нь үйл ажиллагаа хэрэгжүүлэхдээ хөрөнгийг зүй зохистой зарцуулдаг эсэх, зөвлөх ажилтнуудын үйлчилгээний хөлсийг хэрхэн тогтоож, суутгал шимтгэлийг холбогдох журам, зааврын дагуу үнэн, зөв тооцоолж буй эсэх нь анхаарал татахуйц байгаа тул дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

Мөн төслийн 2 дугаар дэд зорилт "Аж ахуйн нэгжүүдэд цар тахлын хүндрэлийг даван туулахад үзүүлэх санхүүгийн дэмжлэг"-ийн хүрээнд төслөөс Ажилгүйдлийн даатгалын санд 4,267,500.0 мянган төгрөгийг төвлөрүүлсэн нь анхаарал татахуйц байгаа тул дараагийн түвшинд дэлгэрэнгүй судлах нь зүйтэй гэж үзлээ.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Зардлын данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Тайлант хугацаанд төсөл хэрэгжүүлэгч нэгжийн 2 ажилтны цалинг 666.1 мянган төгрөгөөр илүү, мөн 2 ажилтны цалинг 404.6 мянган төгрөгөөр дутуу тооцож олгосон нь "Төсвийн тухай хууль"-ийн 6 дугаар зүйлийн 6.3.2 "Санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах" гэсэн заалттай нийцэхгүй байна.

1.2. Эрсдэл:

Холбогдох стандарт, хууль, тогтоомж зөрчигдөх;

1.3. Өгсөн зөвлөмж:

Ажилтнуудын цалинг сүлжээ, журам, зааврын дагуу үнэн, зөв тооцож олгож байх.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

2. Тайлант хугацааны зорилтын хэрэгжилттэй холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Төсөл хэрэгжүүлэгч нэгж нь 2020 онд давхардсан тоогоор нийт 3,310 хүнд 14 удаагийн сургалт зохион байгуулахаар төлөвлөсөн боловч тайлант хугацаанд 3 удаагийн сургалтыг зохион байгуулсан байна. Сургалтуудыг цахимаар зохион байгуулах талаар тодорхой арга хэмжээ аваагүй, сургалтаар хүргэх байсан мэдлэг, мэдээллийг түгээх зорилтот үүргээ хийж гүйцэтгээгүй байна. Энэ хугацаанд сургалттай холбоотой төсөвлөсөн зардлыг гаргаагүй хэдий ч сургалтын үйл ажиллагаа эрхлэх зорилгоор түрээсэлсэн оффисын талбайн түрээс, зөвлөх үйлчилгээний ажилтны цалин зэрэг тогтмол зардлууд үр ашиггүй зарцуулагдсан байна. Энэ нь Сангийн сайдын 2015 оны 196 дугаар тушаалаар батлагдсан "Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам"-ын 8 дугаар зүйл 8.1.2 "Төсөл, арга хэмжээний үйл ажиллагааг дунд хугацаанд төлөвлөж, батлагдсан төлөвлөгөөний дагуу тогтоосон хугацаанд үр дүнтэй, бүрэн хэрэгжүүлэх, төслийн хэрэгжилтийг энэхүү төлөвлөгөөний хүрээнд үнэлэх" гэсэн заалттай нийцэхгүй байна.

2.2. Эрсдэл:

Холбогдох стандарт, хууль, тогтоомж зөрчигдөх, байгууллагын жилийн зорилт хэрэгжээгүй байх, үргүй зардал гаргасан байх;

2.3. Өгсөн зөвлөмж:

Төсөл хэрэгжүүлэгч нэгжийн жилийн зорилтыг хэрэгжүүлэх талаар анхаарч ажиллах, цаашид сургалтыг танхимаар зохион байгуулах нь зохистой эсэх болон сургалтуудыг цахимаар зохион байгуулбал холбогдох зардлыг арвилан хэмнэх боломжтой эсэхийг судалж, зээлийн хөрөнгийг үр ашигтай зарцуулах талаар тодорхой шийдвэр гаргаж ажиллах.

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2021			САГ-2021/78/СТА-ТХН
Шалгагдсан байгууллагын нэр:	"Экспортыг дэмжих төсөл"		Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Тайлант хугацаанд төсөл хэрэгжүүлэгч нэгжийн 2 ажилтны цалинг 666.1 мянган төгрөгөөр илүү, мөн 2 ажилтны цалинг 404.6 мянган төгрөгөөр дутуу тооцоолон тооцооллын алдаа гаргасан байна.	1,070.8	Зөвлөмж өгөв.	Төслийн зохицуулагч, Санхүүгийн ажилтан	А.Хашцэцэг, Б.Дөлгөөн
2	Төсөл хэрэгжүүлэгч нэгж нь 2020 онд давхардсан тоогоор нийт 3,310 хүнд 14 удаагийн сургалт зохион байгуулахаар төлөвлөсөн боловч тайлант хугацаанд 3 удаагийн сургалтыг зохион байгуулсан байна. Энэ хугацаанд зохион байгуулаагүй сургалттай холбоотой төсөвлөсөн зардлыг гаргаагүй хэдий ч сургалтын үйл ажиллагаа эрхлэх зорилгоор түрээсэлсэн оффисын талбайн түрээс, зөвлөх үйлчилгээний ажилтны цалин зэрэг тогтмол зардлууд үр ашиггүй зарцуулсаар байна.	-	Зөвлөмж өгөв.	Төслийн зохицуулагч, Санхүүгийн ажилтан	А.Хашцэцэг, Б.Дөлгөөн
3	Төсөл хэрэгжүүлэгч нэгж нь шилэн дансны цахим хуудсанд байршуулах 19 төрлийн 149 мэдээллээс 4 мэдээллийг огт мэдээлээгүй, 84 мэдээллийг хугацаа хоцорч мэдээлсэн байна.	-	Албан шаардлага өгөв.	Төслийн зохицуулагч, Санхүүгийн ажилтан	А.Хашцэцэг, Б.Дөлгөөн
4	Төсөл хэрэгжүүлэгч нэгж нь 2020 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон санхүүгийн тайланд 1,604.6 мянган төгрөгийн авлага, 92.8 мянган төгрөгийн өглөгийн үлдэгдэл тайлагнасан байна.	1,697.6	Албан шаардлага өгөв.	Төслийн зохицуулагч, Санхүүгийн ажилтан	А.Хашцэцэг, Б.Дөлгөөн
5	Төсөл хэрэгжүүлэгч нэгж нь тайлант хугацаанд 1 м.км-ын үнэлгээ нь сарын 43.3 мянган төгрөг бүхий 268 м.кв оффисийн талбайг нийт 104,485.3 мянган төгрөгөөр түрээсэлж 58 м.кв буюу 28,887.8 мянган төгрөгийн илүү түрээсийн зардал гаргасан байна.	28,887.8	Албан шаардлага өгөв.	Төслийн зохицуулагч, Санхүүгийн ажилтан	А.Хашцэцэг, Б.Дөлгөөн
ДҮН		31,656.2			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25

№ 121/АД160057

Улаанбаатар хот

САГ-2021/78/СТД-ТХН
Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Экспортыг дэмжих төслийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төсөл хэрэгжүүлэгч нэгж нь байгууллагын шилэн дансны цахим хуудсанд байршуулах нийт 19 төрлийн 149 мэдээллээс 4 мэдээллийг мэдээлээгүй, 84 мэдээллийг хугацаа хоцорч мэдээлсэн байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т "Мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3-т "Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.4.1 "Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлтийг долоо хоногийн дотор мэдээлнэ" гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4 дүгээр зүйлийн 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлж, мэдээллийг байгууллагын шилэн дансны цахим хуудсанд хугацаанд нь, үнэн зөв, ил тод байршуулж, биелэлтийг 2021 оны 6 дугаар сарын 10-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Экспортыг дэмжих төслийн зохицуулагч А.Хашцэцэг, санхүүгийн ажилтан Б.Дөлгөөн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц. Наранчимэг

Ц.НАРАНЧИМЭГ

АХЛАХ АУДИТОР
ГРАНТ ТОРНТОН АУДИТ ХХК-ИЙН
АУДИТОР

М. Батцож

Л.НЯМТӨМӨР

М. Батцож

М.БАТЦООЖ

9086109
9019120396



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25

№ 122/Д0160057

Улаанбаатар хот

САГ-2021/18/СТА-ТХН
Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Экспортыг дэмжих төслийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төсөл хэрэгжүүлэгч нэгж нь тайлант хугацаанд 1 м.км нь сарын 43.3 мянган төгрөгийн үнэлгээтэй 268 м.кв оффисын талбайг нийт 104,485.3 мянган төгрөгөөр түрээсэлсэн бөгөөд 58 м.кв талбайг нь үр ашиггүй түрээслэж, түүнд ногдох 28,887.8 мянган төгрөгийн илүү түрээсийн зардал гаргасан байна.

Энэ нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 01-р хуралдааны шийдвэрийн 1-р зүйлийн 1.1-т "Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компаниудын бусдаас түрээсэлдэг байх 1 м.кв талбайн түрээсийн төлбөрийн дээд хязгаарыг 30,000.0 мянган төгрөгөөс ихгүй байлгах"; Засгийн газрын 120 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчийн албан ажлын унаа, өрөөний талбайн хэмжээ, тавилга, хэрэгслийн нийтлэг жишиг"-ийн 4 дүгээр зүйлд "Нэг дэс түшмэлд ногдох албан ажлын өрөөний талбай дунджаар 8 ам метр байна"; Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4 дүгээр зүйлийн 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, төсвийг үр ашигтай, хэмнэлттэй, байхаар төлөвлөн, зарцуулж, дээрх зөрчлийг арилгаж, биелэлтийг 2021 оны 6 дугаар сарын 10-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Экспортыг дэмжих төслийн зохицуулагч А.Хашцэцэг, санхүүгийн ажилтан Б.Дөлгөөн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АХЛАХ АУДИТОР
ГРАНТ ТОРНТОН АУДИТ ХХК-ИЙН
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

Л.НЯМТӨМӨР

М.БАТЦООЖ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25

№ 123/АД160057

Улаанбаатар хот

САГ-2021/48/СТД-ТХН
Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Экспортыг дэмжих төслийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төсөл хэрэгжүүлэгч нэгж нь 2020 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон санхүүгийн тайланд 1,604.6 мянган төгрөгийн авлага, 92.8 мянган төгрөгийн өглөгийн үлдэгдэл тайлагнасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалтыг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө" гэсэн заалт болон Монгол Улсын Ерөнхий Аудиторын А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4 дүгээр зүйлийн 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Хууль тогтоомжийг хэрэгжүүлж, авлага болон өглөгийн үлдэгдлийг барагдуулж, биелэлтийг 2021 оны 6 дугаар сарын 10-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Экспортыг дэмжих төслийн зохицуулагч А.Хашцэцэг, санхүүгийн ажилтан Б.Дөлгөөн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АХЛАХ АУДИТОР

ГРАНТ ТОРНТОН АУДИТ ХХК-ИЙН
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

Л.НЯМТӨМӨР

М.БАТЦООЖ